

---

MONGOLIAN ACADEMY OF SCIENCES  
INSTITUTE OF HISTORY AND ARCHAEOLOGY

**The Mongolian Kanjur**  
*International Studies*

Editor-in-Chief: S. Chuluun

Ulaanbaatar 2017

HHA 63.3 (5)  
ДAA 950  
O-467

*The present volume includes articles by international scholars covering many aspects of the study of the Mongolian Kanjur including its history, collections, prints, colophons, individual texts, and contributions made by Mongolian monks to Kanjur studies. The Institute of History and Archaeology, Mongolian Academy of Sciences, in collaboration with the International Association for Mongol Studies, organised an international conference, "The Buddha's Words: International Conference on the Study of the Mongolian Kanjur", in Ulaanbaatar on 20–23 July, 2017. The conference topic was chosen to sit within the framework of the Institute's project "Fundamental research on the Mongolian Kanjur including a large-scale translation programme of the Kanjur and the Tanjur, the ancient spiritual heritage of the Mongols, into the modern Mongolian". At the conference Mongolian and foreign researchers gave presentations on their research: in addition to Mongol attendants, academics came from Saint-Petersburg, Ulan-Ude and Kyzyl in Russia, from Tokyo and Kyoto in Japan, Cambridge University in the UK, University of Warsaw in Poland, Huhhot and Tung lio in China, Charles University in the Czech Republic, the Berlin State Library in Germany, University of Santa Barbara, California in the USA, ELTE University in Hungary, and representatives from several other institutions. The present volume serves as a basic handbook for researchers, PhD candidates and students who study the Kanjur from philological, religious and other points of views, as well as to everyone interested in Mongolian Buddhism.*

**The Mongolian Kanjur International Studies**

Editor-in-Chief: S.Chuluun

Revision: Krisztina Teleki

Designer: D.Oyun

Paper size: 172x245

Copy: 300

*The research work was made possible thanks to the grant (SST\_051/2015) "Fundamental research on the Mongolian Kanjur including a large-scale translation programme of the Kanjur and the Tanjur, the ancient spiritual heritage of the Mongols, into the modern Mongolian" in Mongolia in 2016-2017, and to the financial support of the (15ZDB125) "Study of the Kanjur and the Tanjur Mongolian".*

ISBN 978-99978-976-3-3

© Copyright by Chuluun Sampildondov and The Institute of History and Archaeology, Mongolian Academy of Sciences

## ГАРЧИГ

### Мэндчилгээ

- ◆ С.Чулуун: Өмнөтгөл ..... 9
- ◆ Биргалан Агнэш: Мэндчилгээ ..... 15

### Ганжуурын судлал – түүх, цуглуулга

- ◆ Каренина Коллмар-Пауленз: Монгол Ганжуур судлалын одоогийн байдлын тухай товч мэдээлэл ..... 17
- ◆ К.В.Алексеев: Монгол гар бичмэлийн Ганжуурын хуулбаруудыг харьцуулах нь ..... 37
- ◆ А.А.Туранская: Лигдэн хааны Ганжуурын өнөө үед хадгалагдсан хуулбаруудын тухай товч мэдээлэл ..... 51
- ◆ Н.В.Ямпольская: Орос ба Европын цуглуулгад буй гар бичмэл гурван монгол Ганжуурын хэсгээс ..... 61
- ◆ Ц.П.Ванчикова: Оросын ШУА-ийн Сибирийн салбарын Монгол, төвд, буддын судлалын хүрээлэнгийн Дорно дахины гар бичмэл ба барын номын төвд хадгалагдаж буй монгол гар бичмэл Ганжуурын тухай ..... 73
- ◆ С-Х.Д.Сыртыпова: Буриадын Цүгэлийн дацангийн түвэд Ганжуурын гар бичмэлийн тухай ..... 81
- ◆ У.П.Бичелдей: Тувагийн үндэсний музейн Ганжуурын цуглуулгын тухай танилцуулга ..... 101
- ◆ Хурц: Дайчин улсын үед монгол Ганжуурыг гаргуулж барласан зарим асуудлыг шинжлэх нь ..... 108
- ◆ Сэцэнбилэг: Монгол Ганжуурын орчуулга ба бар хэвлэлийн түүхэн тойм ..... 116
- ◆ Наками Тацуо: ХХ зууны эхээр япончууд Монгол Ганжуурыг эрэн сурвалжилсан нь: Эзэн хааны их сургуулийн “мартагдсан” Ганжуурын тухай ..... 135
- ◆ Такаши Мацукава: Японд хадгалагдаж буй Монгол Ганжуур, Данжуурын тухай товч мэдээ ..... 151

### Судрын харьцуулалт, дүн шинжилгээ

- ◆ Д.Бүрнээ: Ганжуурыг орчуулахад Ширээт гүүшийн оруулсан хувь нэмэр ..... 158
- ◆ Т.Булган: “Билгийн зүрхэн судрын мэдэгдэхүүн-утгаас” эргэцүүлэхүй ..... 168

- ◆ М.Гантуяа: Монгол Ганжуур дахь Билиг барамидын судруудын тухай ..... 175
- ◆ Н.С.Яхонтова: Санкт-Петербургийн Монгол Ганжуур дахь “Алтангэрэл судар”-ын гурван хувилбарын тухай ..... 207
- ◆ Р.Отгонбаатар: Ганжуурын зарим боть номыг монгол хүний хураангуйлсан жишээ ..... 215
- ◆ Ондрей Срба: “Огторгуй газрын найман гэгээн” судрын асуудалд: “Харш засах найман гэгээн” судрын нэгэн шинэ хувилбар ..... 224
- ◆ Г.Мягмарсүрэн: Монголын бурханы шашны түүхэнд холбогдох гурван судрын тухай өгүүлэх нь ..... 247

### **Уламжлал, орчуулга болон бусад асуудал**

- ◆ Ш.Сонинбаяр: Далай гүний хошууны гавж Намжалсодномванчүг, Номгоны сүмийн Дара эх ламтан Агваанчүлтэмжамц нарын “Ганжуурын товъёг жүдрэм”-ийн тухай өгүүлэх нь ..... 259
- ◆ Р.Бямбаа: Монголчуудын Ганжууртай холбоотой хийсэн зүйл болон ном бүтээлүүд ..... 262
- ◆ Н.Амгалан: Ганжуур судар хадгалж байсан сүм хийдүүдийн бүртгэл ..... 290
- ◆ Михаэл Балк: Монгол Ганжуурыг хэл шинжлэлийн үүднээс авч үзэх нь ..... 305
- ◆ Анна Д.Цендина: Академич Цэндийн Дамдинсүрэнгийн гэр музейд хадгалагдаж байгаа Ганжуур болон Ганжууртай холбогдолтой судруудын тухай ..... 321
- ◆ Ц.Уранчимэг: Ганжуурын монгол орчуулгууд болон Ганжуурын зураг дүрслэл дээр хийсэн анхны ажиглалтын товч дүгнэлт ..... 327
- ◆ А.А.Базаров: Монгол Ганжуур ба Буриад зоны өдөр тутмын номын соёл ..... 335
- ◆ Ч.Гансүх: Монгол Ганжуурын гарчгийн тухай ..... 341
- ◆ Телеки Кристина: Хүрээ барын Ганжуурыг бүтээсэн тухай ..... 345



## TABLE OF CONTENTS

### Greetings, Addressings

- ◆ S. Chuluun: Foreword ..... 9
- ◆ Ágnes Birtalan: The Standard of Buddhist Teaching –  
The Canon ..... 15

### Kanjur Studies – History and Collections

- ◆ Karénina Kollmar-Paulenz: The Mongolian Kanjur –  
Some Remarks about the Current State of Research ..... 17
- ◆ Kirill Alekseev: On the Correlations between the Copies  
of the Mongolian Manuscript Kanjur ..... 37
- ◆ Anna Turanskaya: A Brief Survey on the existing Copies  
of Ligdan Khan’s Kanjur ..... 51
- ◆ Natalia Yampolskaya: Fragments of three Mongolian Kanjur  
manuscripts in Russian and European collections ..... 61
- ◆ Tsymzhit P. Vanchikova: The Mongolian Handwritten  
Kanjur in the Centre of Oriental Manuscripts and  
Xylographs of the IMBT SB RAS ..... 73
- ◆ Surun-Khanda D. Syrtyanova: The Nine Jewels Kanjur  
of Tsugolskiy Datsan ..... 81
- ◆ Uliana Bicheldey: Kanjur and Other Sūtras preserved  
in the Collections of the National Museum  
of the Republic of Tuva ..... 101
- ◆ Hurča: Questions of the Mongolian Kanjur’s Translation  
and Printing in the Period of the Qing Dynasty ..... 108
- ◆ S. Setsenbilig: Historical Overview of the Mongolian  
Kanjur’s Prints ..... 116
- ◆ Nakami Tatsuo: The Japanese Search for the Mongolian  
Kanjur in the early 20<sup>th</sup> century - a forgotten Mongolian  
Kanjur at the Tokyo Imperial University ..... 135
- ◆ Takashi Matsukawa: A Brief Introduction to the Volumes  
of the Mongolian Kanjur and Tanjur preserved  
in Japanese Collections ..... 151

### Comparison and Analysis of Sūtras

- ◆ D. Burnee: Siregetü güüsi’s Contribution to the Translation  
of the Mongolian Kanjur ..... 158

- ◆ T. Bulgan: Interpretation of the Prajñāpāramitāhṛdaya or Heart Sūtra, a text in the Mongolian Kanjur ..... 168
- ◆ M. Gantuya: The Prajñāpāramitā Sūtras in the Mongolian Kanjur ..... 175
- ◆ Natalia Yakhontova: Comparing texts of *Altan Gereltü Sudur* included in the Kanjur and Separate Ones (A Quantitative Approach) ..... 207
- ◆ R. Otgonbaatar: Kanjur Texts summarized by the Mongols ..... 215
- ◆ Ondrej Srba: About a 17<sup>th</sup> century Mongolian Manuscript of the Qutuytu Oytaryui yaǰar-un Naiman Gegegen (Gnam sa snang brgyad) ..... 224
- ◆ G. Myagmarsuren: A Study on the Vimālaprabhāparipṛcchā and the Ārya Gośṛṇavyākaraṇa ..... 247

### **Transmission, Translation, and Other Aspects**

- ◆ Sh. Soninbayar: Lists including the Lineages of Transmission of the Mongolian Kanjur written by Namjalsodnomvanchug gavj of Dalai gun banner and Nomgonii Dara ekh lam Agvaanchultemjamts ..... 259
- ◆ R. Byambaa: Special Customs and Scriptures of the Mongols concerning the Kanjur ..... 262
- ◆ N. Amgalan: A Register of old Mongolian Monasteries possessing the Kanjur ..... 290
- ◆ Michael Balk: Approaches to the Kanjur from a Philological Perspective ..... 305
- ◆ Anna D. Tsendina: A Set of the Kanjur and Other Kanjur Texts kept in the Ts. Damdinsuren Home Museum ..... 321
- ◆ Ts. Uranchimeg: Preliminary Remarks on the Mongolian Translations of the Kanjur and their Illustrations ..... 327
- ◆ Andrei A. Bazarov: The Mongolian Kanjur and Everyday Sacred Book Culture in Buryatia ..... 335
- ◆ Ch. Gansuh: Analysis of the Mongolian Kanjur's colophon ..... 341
- ◆ Teleki Krisztina: A compilation of the Urga Kanjur ..... 345

**“ОГТОРГУЙ ГАЗРЫН НАЙМАН ГЭГЭЭН”  
СУДРЫН АСУУДАЛД:  
“ХАРШ ЗАСАХ НАЙМАН ГЭГЭЭН” СУДРЫН  
НЭГЭН ШИНЭ ХУВИЛБАР**

Ондрей Срба  
Масарикийн их сургууль, Брно; Карлын Их Сургууль,  
Прага<sup>282</sup>

A 17<sup>th</sup> or early 18<sup>th</sup> century Mongolian Manuscript of *Qutuγtu oγtarγui γaγar-un naiman gegegen* (Tib. *gnam sa snang brgyad*): *Oγtarγui γaγar-un naiman gegegen*, or the Sūtra of Eight Luminous of Heaven and Earth is a widespread and frequently used short canonical text in Mongolian Buddhism. Previously, two profoundly different versions of the *sūtra*, both originating in Chinese originals, have been described by W. Heissig and L. Ligeti. Textologically rather unified Version A was attested as early as in the 14<sup>th</sup> century findings in Khara Khoto and later incorporated into the Beijing xylographic Kanjur. The less common Version B is attested for the first time in Olon süm-e (16<sup>th</sup> century) and at the beginning of the 18<sup>th</sup> century was included into the Beijing xylographic *Sundui* and printed also as a separate blockprint. I have described two manuscripts of Version B found in the collection of Charles University, Prague, which show substantial differences in their translation from the blockprinted versions. Manuscript marked Version Bd relates supposedly to the 17<sup>th</sup> century. This article brings a comparison of titles used in various versions of the *sūtra* and of the polyglot quotations of names of the Eight Bodhisattvas found in Versions B.

Тус өгүүлэлд монгол бичгийн орчуулгын Найман гэгээн судрын, хятад, тод үсгийн Найман гэгээн судруудтай харилцаа холбооны асуудлыг товчоор өгүүлээд Б хувилбар буюу “Харш засах найман гэгээн” судрын сонгодог өмнөх үеийн хэлний шинжтэй нэгэн шинэ хувилбарыг (*Qutuγtu oγtarγui γaγar-un naiman gegegen neretü yeke kölgen sudur*, хуулбар нь Карлын их сургуульд буй) хэл бичигзүй, орчуулгын онцлогийн үүднээс танилцуулах зорилго тавьж байгаа юм.

<sup>282</sup> Participation in the conference and finalization of this article was possible thanks to the support of the Czech Science Foundation (Grant GA15-12215S).

## Оршил

Монгол эртний судар номын дунд богино гарчгаараа “Найман гэгээн” (хят. *ba yang* 八陽) алдаршсан агуулга, орчуулгын хэдэн зүйлийн хувилбартай зохиолууд байдаг. Найман гэгээн судрын монгол хэлний орчуулгын хоорондоо ялгаатай нэлээд хэдэн хувилбар олддоод байгаа.

Монгол бурханы шашны ном судрын орчуулгын түүхэн хөгжлийн явцад “Огторгуй газрын найман гэгээн” судрууд нэлээд эртний үүсэлтэй болно. 16-р зууны үед хамаарах Олон сүмийн тасархай олдворуудын дунд хоёр төрлийн агуулгатай “Найман гэгээн судар” багтаасан байгаа гэдгийг В.Хайссиг<sup>283</sup> дэлгэрэнгүй задлан шинжилж мэдээлсэн байна. Олон сүмийн гар бичмэлийн дундах “Найман гэгээн” судрууд 17-18-р зууны үеийн монгол орчуулгын “Найман гэгээн” судрын эх үүсвэр болох магадлалтай гэж В. Хайссиг дүгнэв.

Европын хэлүүдээр “Найман гэгээн” судрын нэрийг анх удаа герман хэлээр *Sūtra der „Acht Erscheinungen,”*<sup>284</sup> хожим *Sūtra für das Abwenden von Unheil, genannt die Acht Strahlenden,*<sup>285</sup> франц хэлээр *Sūtra des huit agrégats de lumière, Sūtra des huit lumineux du ciel et de la terre*<sup>286</sup> хэмээн орчуулав.

Тус судрын гол зорилго хийгээд “Найман гэгээн” хэмээгч юун хэмээвээс тус сударт ийн мэт айлтгаруун:

[Бурхан багш] *bi olan amitan / ba: öglige-yin ejen / boluysan-tur yeke asiγ / tusa-yin tulada: ene / oγtaryui yaγar-un naiman / gegegen neretü nom-i nomlaysan / gegegen jayayatur tngri yaγar: / qamuγ luus amurliyad / sayin jiryalang-iyar jasamui: /*

*tegün-tür oγtaryui kemeküi / dalai-yin qoi-tur aγči: / sümbür ayula-yin tere / jibqulang-tu dalai-yin / gerel anu dalai-ača degegside / kürügsen tere sümbür / ayula-yin gerel bolai: tegüni / oγtaryui kemen nereyidüyü: / yaγar kemebesü dalai-daki / twib-üd boluyu: yeke / dalai-yin dumda-ača dörben / jüg-ün ner-e dörben / twib nereyidüyü gegegen / kemebesü: oγtaryui yaγarun/ qoγur dumda inü aγči: / amitan yabuqun bügüde / amisququi amitan amin / jegügsen yerü bügüde boluyu: / naiman kemebesü tere bügüde- / tür erketü boluysan yeke / küčütü tngri terigüten / naiman ayimay ulus [= luus?] boluyu.*<sup>287</sup>

<sup>283</sup> Heissig, W.: *Die mongolischen Handschriften-Reste aus Olon süme Innere Mongolei (16.-17. Jahrhundert)*. (Asiatische Forschungen 46) Otto Harrassowitz, Wiesbaden 1976, т. 300-322.

<sup>284</sup> Weber, J. – Huth, G.: *Das buddhistische Sūtra der „Acht Erscheinungen.” Zeitschrift der Deutschen Morgenländischen Gesellschaft Vol. 45 (1891), т. 577-591.* Төвд (А) хувилбарын галиг болон герман орчуулга.

<sup>285</sup> Heissig, W.: *Die Pekingener Lamaistischen Blockdrucke in mongolischer Sprache. Materialien zur mongolischen Literaturgeschichte.* Otto Harrassowitz, Wiesbaden 1954, т. 162. (Цаашид PLB хэмээн товчлов.)

<sup>286</sup> Ligeti, L.: *Autour du Säkiz yükmäk yaruq. Studia Turcica.* Ed. by Ligeti, L. Akadémiai Kiadó, Budapest 1971, т. 291-319.

<sup>287</sup> Прагын цуглуулгын Mong. В 1 гар бичмэл, 3г-4г.

### “Найман гэгээн” судрын хятад хувилбар

Олон хэлээрх, олон хувилбар бүхий “Найман гэгээн” судрууд нийтдээ дундад үеийн Төв Ази, Хятадын олон шашин уламжлалын синкретик орчин тойрны үр дүн болно. Эдүгээ бидэнд мэдэгдэх монгол орчуулгууд бүгдээрээ төвд эхээс орчуулсан боловч, төвд эх нь угтаа хятад эхээс орчуулсан байгаа гэж эрдэмтэд үздэг. Тиймээс “Найман гэгээн судар” бол хятад хэлнээс монгол хэлэнд орчуулагдаж ирсэн цөөхөн судрын нэг нь болох юм.

“Найман гэгээн” гэсэн ойлголтыг хятад хэлээр *ba yang* 八陽 хэмээдэг бөгөөд хятад хэлний Гурван аймаг сав дотор (*Taishō Tripitaka* 大正新脩大藏經-д орсон байдлаар) “Найман гэгээнийг” өгүүлдэг дараах зохиолууд үүссэн буюу хятад хэлэнд орчуулагдсан цаг үеийн дэс дарааллаараа багтана:

*Taishō Tripitaka*-гийн Судрын чуулган хэмээх аймагт (*Kyōshū-bu* 經集部, *Sūtrasannipāta*) энэхүү таван ном буй:

No. 427 *Fo shuo ba ji xiang shen zhou jing* 《佛說八吉祥神咒經》: Орчуулагч нь Youposai (*upāsaka*) Чжицянь / Zhiqian (吳月氏) 優婆塞支謙 (Гурван улсын үе, 220–280).

No. 428 *Ba yang shen zhou jing* 《八陽神咒經》: Орчуулагч нь Дуньхуанд амьдарч байсан орчуулагч хувраг Чжуфахо даши / Zhufahuo dashi (月氏 三藏) 竺法護大師 (237–316).

No. 429 *Fo shuo ba bu fo ming jing* 《佛說八部佛名經》: Орчуулагч нь Энэтхэгийн бярман гаралтай хувраг Цюйтаны Божолучжи / Qutan Boguoliuzhi (天竺 婆羅門) 瞿曇般若流支, самгард нэрээр Gautamaprajñāguci (6-р зууны нэгдүгээр хагас).

No. 430 *Ba ji xiang jing* 《八吉祥經》: Орчуулагч нь самгард нэрээр Samhavarman буюу Saṅgharāla, хятад нэрээр Санцеполо / Sengqieroluo 僧伽婆羅 (амьдарсан цаг үе нь тодорхой бус).

No. 431 *Ba fo ming hao jing* 《八佛名號經》: Орчуулагч нь самгард нэрээр Jñānagupta, хятад нэрээр Шэнацзюэдо / Shenajueduo (天竺 三藏) 闍那崛多 (523–600), Энэтхэг гаралтай хувраг.

Монгол хэлээр дэлгэрч байсан “Найман гэгээн судар”-т агуулгаараа хамаг ойр болох судар харин *Taishō Tripitaka*-гийн хамгийн эцэст багтжээ:

No. 2897 *Fo shuo tian di ba yang shen zhou jing* 《佛說天地八陽神咒經》: Орчуулагч нь хувраг Ицзин / (Tang Sanzang Fashi) Yijing 唐三藏法師義淨 (635–713).

*Fo shuo tian di ba yang shen zhou jing* гэсэн судар хятад эрдэмтдийн дунд заримдаа *weijing* 偽經 буюу “хуурмаг судар” (pseudoepigraphic/ apocryphal) хэмээгддэг.<sup>288</sup> Учир нь тус судар бурханы шашны өмнөх арга

<sup>288</sup> 鄭朝通: 敦煌寫本《佛說八陽神咒經》之疑偽及其所反映的社會文化意義析論. enlight.lib.



билгийн сургаал, таван махбодын үзэл, хятад одон зурхайн зэрэг бомбын болон Күнзийн суртгаалын хятадын уугуул ухагдахууныг агуулна. Үүнээс болоод *Taishō Tripitaka*-г харгуулан эмхтгэсэн Кэйки Ябуки 矢吹 慶輝 авгай тус судрыг 85-р боть буюу “сэжиглэлтэй, мадагтай [номын] бүлэг” (*Giji-bu* 疑似部)-т ангилан оруулав. Тус судар орчуулагдсан цагаасаа ихэд дэлгэрч байсны нэгэн гэрч бол энэ судар Дуньхуангийн олдворын дунд тохиолдмуй (жишээ нь Их Британийн Музейн Or.8210/S.252 тоот гар бичмэл).

“Найман гэгээн” судрын эртний Уйгар орчуулгын Япон дахь хадгалагдаж буй тасархай хэсгүүдийг Haneda Tōgu<sup>289</sup> зэрэг эрдэмтэд, Герман дахь тасархай олон үлдэгдлийг W.Bang, A. von Gabain, G.R. Rachmati нар,<sup>290</sup> Санкт-Петербург хотод хадгалагдсан гар бичмэлийг анх В.Радлов<sup>291</sup> судлаад нийтлүүлсэн билээ.<sup>292</sup>

## Монгол хэлний “Найман гэгээний” хувилбарууд болон Прагын цуглуулга дахь “Найман гэгээн” судруудын тойм

### 1. Модон бар

Чех улсын анхны монголч эрдэмтэн Профессор П.Поухагийн (1905–1986) үеэс бүрдэж эхэлсэн Карлын их сургуулийн монгол эртний ном бичгийн цуглуулгад эдүгээ “Найман гэгээн” судруудын бар болон гар бичмэлийн хэдэн хувилбар буй бөгөөд тэднийг тус илтгэлдээ товч танилцуулахын сацуу дунд нь эх бичгийн талаас онцгой байр суурийг эзэлдэг 17-р зууны үүсэлтэй гэмээр нэгэн гар бичмэлийг онцлон дурдъя.

Монгол хэлээр орчуулсан “Найман гэгээн” судрын хамгийн эртний тасархай үлдэгдэл Эзнээ дэх Хар хотын тууриас олдсон бичгийн дурсгалын дунд буй хэмээн доктор Р.Отгонбаатар тодруулав. 14-р зууны маягийн энэхүү F20:W64 дугаартай модон барын хэвлэмэл хуудасны

[ntu.edu.tw/FULLTEXT/JR-MAG/mag216867.doc](http://ntu.edu.tw/FULLTEXT/JR-MAG/mag216867.doc).

<sup>289</sup> Ханеда Торугийн номзүйг Ligeti, L.: *Autour du Säkiz yükmäk yaruq*. т. 292-аас үзнэ үү.

<sup>290</sup> Bang, W. – von Gabain, A. – Rachmati, G. R.: *Türkische Turfantexte VI. Das buddhistische Sūtra Säkiz yükmäk*. Berlin 1934. (Sonderausdruck aus den Sitzungsberichte der Preussischen Akademie der Wissenschaften, Phil. Hist. Klasse. 1934. X.)

<sup>291</sup> Radloff, W.: Kuan-ši-im Pusar. Eine türkische Übersetzung des XXV. Kapitels der chinesischen Ausgabe des Saddharmapundarīka. In: *Bibliotheca Buddhica XIV*. St. Petersburg 1911, т. 90–103; Radloff, W.: *Uigurische Sprachdenkmäler*. Ed. by Malov, S. Leningrad 1928.

<sup>292</sup> Уйгар хувилбаруудыг судалсан хятад судалгаануудыг дараах хоёр өгүүлэлээр төлөөлүүлж дурдъя: Feng Jiasheng 馮家升: Keben huihuwen “Fo shuo tian di ba yang shen zhou jing” yanjiu – Jian lun Huihuren dui “Dazangjing de gongxian 刻本回鶻文〈佛說天地八陽神咒經〉研究-兼論回鶻人對於〈大藏經〉的貢獻. *Kaogu xuebao* 考古學報 9 (1955), т. 183–192, 277–278.; Liu Yuanchun 劉元春: “Fo shuo tian di ba yang shen zhou jing” bianxi: Jian tan Gaochang Huihu fojiao de shehui wenhua yiyun 《佛說天地八陽神咒經》辨析-兼談高昌回鶻佛教的社會文化意蘊. *Xiyu yanjiu* 西域研究 1996, Vol. 1, т. 50–59.

бичвэр “Найман гэгээн” судрын Аb хувилбартай бичихзүйн онцлогийг үл тооцвол харилцан дүйцэж байна.<sup>293</sup> 16-р зуунд хамааруулах боломжтой “Найман гэгээний” гар бичмэлийн хэдэн тасархай хуудас Олон сүмээс олдсон бөгөөд эднийг Вальтер Хайссиг нарийвчлан судалж, дунд нь А болон В хувилбарын хэсгүүд байгаа гэдгийг батлав.<sup>294</sup>

Монгол орчуулгаар үндсэндээ хоёр зүйлийн “Найман гэгээн судар” байдаг. Монгол оронд хамгийн ихээр дэлгэрсэн, бас Ганжуур дотор орсон зохиолыг Вальтер Хайссиг А орчуулга хэмээн нэрлэсэн. Энэ нь *Fo shuo Ba yang shen zhou jing* 佛說八陽神咒經 гарчигтай хятад эхээс дам орчуулсан зохиол болох бөгөөд хоёр дэд хувилбартай байдаг:

Аа) *Qutuytu oytaryui yajar-un naiman gegegen neretü yeke kölgen sudur. nayan jüil-iyer geyigsen geyigülügen. qutuу-tu ene tarni. nigen jüil-tü nom-un biçig.* Бээжингийн бага хэлбэрийн модон барын хэвлэл, 亡乃 захын тэмдэгтэй, төгсгөлийн үггүй, бар бүтээсэн огноог дурдсангүй (Heissig PLB Nr. 211). Прагын цуглуулгад хэвлэлийн чанар сайтай, гэвч эцсээсээ дутуу нэгэн бар (Mong. D 223, “Найман гэгээний” Ва хувилбарын модон бартай холилдсон) хийгээд тус модон барын нэгэн бүрэн, гэвч хэвлэлийн чанар муу, уншихуйяа бэрх сүүлийн үеийн хэвлэл (магадгүй дахин сийлсэн барын хэвлэл, Mong. B 17).<sup>295</sup>



<sup>293</sup> Yoshida, J. – Chimeddorji: *Study on the Mongolian documents found at Qaraqota*. Yuzan kaku, Tokyo 2008, т. 134 (япон, хятад хэлээр). Хар хотын модон бар: *üdüр beri bayulyaju kür[gen] / ...güdkegsen-ü qoyina bayan sayin bolju / nasun-tur kürkü čöken: ügegü dutayu bolju / ükükü qayaçaqu olan. jarimud tetürü buruyu büsiregčid amitan-u ilyal anu yayun-u tula öbere bolumui: ker ken ber ilaju tegüs ...*; Аа: 22г: *[qoyina sayin] edür beri bayulyaqui: kürgen sögüdkeküi sögüdkegsen-ü qoyina bayan sayin bolju: nasun-dur kürkü čögen ügegü dutayu bolju: ükükü qayaçaqu olan jarim-ud tetürü buruyu-yi bisiregčin amitan-u ilyal inu yayun-u tula: öber-e bolumui: kerken ber ilaju tegüs nöгčigsen-e ...*

<sup>294</sup> Heissig, W.: *Die mongolischen Handschriften-Reste ...*, т. 300–319.

<sup>295</sup> Барын хүрээ 23,3–23,5 см × 6,9–7,1 см, хуудсанд 16–17 мөртэй, Mong. D 223 тоот хуудас 2–13, 16–18, Mong. B 17/1 тоот хуудас 1–34 (эцсээсээ бас дутуу).



Зураг 1. Аа хувилбар (Mong. В 17, fol. 1v-2r).

Ab) *Qutuy-tu oytaryui yaĵar-un naiman gegen neretü yeke kölgen sudur*

Саяхан өгүүлсэн модон бараар төлөөлөгдсөн хувилбар засан шинэчилсэн хэлбэрээр модон барын Ганжуурт оров (*Dandr-a*, 24-р боть, 291v-301v).<sup>296</sup>

Ганжуур дахь хувилбарын төгсгөлийн үгэнд: *Qutuy-tu tngri yaĵar-un naiman gegen yeke kölgen sudur. kitad-un nom-aĉa tamay-a yogaĉaris Krisis rinĉen [bkra shis rin chen] nayirayul-un: ayay-q-a tegimlig Suriyasiri [Sūryaśrī] ber enengsün (?) lab quyilayulĵu: Amasiri [Amaśrī] bayši sayitur ĵokiyajū biĉigülĵū ariyun-a Qadasiri [Ligeti: Anandasiri (?)] kiged-iyer qabtasun-dur ĉoyulyajū: ayui ulus irgen-e tügeĵū delgeregülbei::* гэж өгүүлэв.

Адилхан дэд хувилбар бас тусгай Бээжингийн модон бараар буй бөгөөд тус хувилбарын төгсгөлийн үгэнд өмнөх төгсгөлийн үгнээс зарим нэрийг өөр байдлаар дурдсныг онцолъё. Захын тэмдэг ханз үгүй, хуудас бүр 12 мөртэй энэхүү модон бар: *kitad-un nom-aĉa tamaga yogaĉari Kirisir Irinĉin nayirayulun ayay-q-a tegimlig Suriyasiri ber: Amags[i]d[i] lab quyiyulĵu Amlasiri bayši ber sayitur ĵokiyajū biĉigülĵū: Ariyun-a Qadasiri kiged-iyer qabtasun-tur ĉoyulĵu ayui ulus irgen-e tügeĵū delgeregülbei:: tegüsbe:*<sup>297</sup> гэсэн төгсгөлийн үгтэй.

Тус дэд хувилбар Прагын цуглуулгад үгүй.

<sup>296</sup> Ligeti, L.: *Catalogue du Kanĵur mongol imprimé. Vol. I – Catalogue.* (Bibliotheca Orientalis Hungarica III) Sociéte Kőrösi Csoma, Budapest 1942–1944, т. 159–160.

<sup>297</sup> Тус модон барын гэрэл зураг *Mergen keyid-ün sudur-un ĉiyulyan.* S. Mönġkebatu emkidken nayirayulba. *Öbür mongġol-un surġan kümüĵil-ün keblel-ün qoriy-a, Kökeqota 2012, Vol. III,* т. 3371–3466 гэсэн номд хэвлэгдэв. Төгсгөлийн үг нь 47-р хуудас. Ligeti, L.: *Catalogue du Kanĵur ...*, т. 160 дахь төгсгөлийн үгний галиг: ... *kitad-un nom-aĉa tamay-a yogaĉaris Krašis rin-ĉen nayirayul-un: ayay-q-a tegimlig Sūryaśrī ber enengsün (?) lab quyiyulĵu: Ama(?)-śrī bayši sayitur ĵokiyajū biĉigülĵū ariyun-a Anantasiri (?) kiged-iyer qabtasun-dur ĉoyulyajū: ayui ulus irgen-e tükeĵū* (зүй нь: *tügeĵū*) *delgeregülbei::*



Хоёрдахь буюу В зохиол бол А зохиолоос агуулгаараа эрс ялгаатай, биеэ даасан зохиол болно. Модон барын Монгол Ганжуурт ороогүй. Төвд эхээс орчуулагдсан байх магадлалтай энэхүү хувилбар төгсгөлийн үггүй Бээжингийн модон бар (Heissig PLB Nr. 205) хийгээд 1727, 1729 оны Бээжингийн “Сундуй”-д орсон хувилбараар (Heissig PLB Nr. 67, Nr. 72) төлөөлөгдсөн буй. Тус зохиол нь бас хоёр хувилбартай:

Нэгдэгч дэд хувилбар: Ba) *Qarsi jasaqu naiman gegen neretü sudur*. Бээжингийн бага хэлбэрийн модон бар, захын *nai* 乃 ханзын тэмдэгтэй, төгсгөлийн үг болон огноо үгүй.<sup>298</sup> В. Хайссигийн таамагласнаар Ba, Aa хоёр модон бар 18, 19-р зууны зааг дээр үүссэн бололтой. Aa, Ba модон барууд үсгийн тиг, үзэмж хоорондоо мэдэгдэхүйц ялгаатай боловч нийт хэв маяг, барын хүрээний хэмжээ нь ижилхэн тул нэгэн зэрэг бүтээгдсэн модон бар мөн гэж үзэж байна. В.Хайссиг энэ хоёр модон барыг “замын богцны жижиг хэвлэл” (“kleinen Reisetaschenausgaben”)<sup>299</sup> хэмээн нэрлэв.



Зураг 2. Ba хувилбар (Mong. D 223, fol. 1v, 14r).

<sup>298</sup> Барын хүрээ: 6,9-7,1 × 23,3-23,5 см, хуудсанд 16-17 мөр; Mong. D 223 тоот хуудас 1, 14, 15.

<sup>299</sup> Heissig, W.: *Die Pekingener Lamaistische Blockdrucke...*, т. 162.

Хоёрдогч дэд хувилбар: Bb) *Qutuγ-tu oγtaryui γaγar-un naiman gegen neretü yeke kölgen sudur* гэсэн гарчигтай. 1707, 1727, 1729 оны Бээжингийн барын “Сундуй” буюу *Tarnis-un quriyangγui*-н 83-р ботид орсон. Төгсгөлийн үг, огноо мөн үгүй. “Сундуй”-н хувилбар Прагын цуглуулгад байхгүй.

Үүнээс гадна, Дара Убасанзын дурдалгаар Ойрдын Равжамба Заяа Бандидын орчуулсан тод үсгийн хувилбар буй.<sup>300</sup> Тус хувилбар нийтэд тод үсгийн олон хуулбараар төлөөлөгдсөн байдаг бөгөөд төвд уг эх нь B бүлгийн хувилбарынхтай нэг байсан бололтой. Тийм учраас тод үсгийн “Найман гэгээн”-ийг Bc хувилбар хэмээн тэмдэглэе.

## 2. Гар бичмэл

Прагын цуглуулгад дараах “Найман гэгээн судар”-ын гар бичмэлийн эх буй:

### А хувилбарын гар бичмэл

1. *Naiman gegegen neretü yeke kölgen sudur orušibai*: (Mong. D 197)

Оросын гар үйлдвэрийн цаас, цаасны усан тэмдэг тодорхой үл мэдэгдэх (Ф? М ... ?) бөгөөд үйлдвэрлэсэн огноо, бусад зураглал үгүй (хэмжээ нь: 22,2×7см, 23 хуудас). Палеографийн үүднээс тус гар бичмэлийг 18, 19-р зууны зааг дээр үүссэн гэж таамаглаж болно.

2. *Qutuγtu degedü oγtaryui γaγarun naiman gegegen neretü yeke kölgen sudur orušibai:: sayin buyan delgeretügei::* (Mong. D 134)

Оросын механикжуулсан үйлдвэрийн гялгар гадаргуутай цаас, цаасанд тамгалсан үйлдвэрийн тэмдэг *Успенской фабрики №7* (үйлдвэр нь 1886 онд байгуулагдав). Хулсан бийрийн бичлэг, 19-р зууны эцэс, 20-р зууны эхэн (22×8,7см, 23 хуудас).

3. *Naiman gegen neretü yeke kölgen sudur orusiba*: (Mong. C 46)

Судрын хэлбэрт хоёр давхар хятад муутуу цаасан дээрх усан бийрийн бичлэг. (22,3×10,5 см, 22 хуудас) 19-р зууны хоёрдугаар хагас.

### В хувилбарын гар бичмэл

1. *Qutuγ-tu oγtaryui γaγarun [qarsi γasaγči] naiman gegegen neretü yeke kölgen sudur* (Mong. B 1) – цааш нь Bd хэмээн тэмдэглэв.

Олон давхар нааж нийлүүлсэн зузаан хятад цаасан дээр маш уран болон тогтуун бичлэгийн маягаар бүтээсэн гар бичмэл. Бичгийн тиг 17-р зууны хоёрдугаар хагастай тохирдог боловч 18-р зууны эхэн үеийн модон барын бичгийн тигийн нөлөөг бас үгүйсгэхийн аргагүй. 21,3×9,2 см хэмжээтэй, 34 хуудастай, 33, 34-р хуудас чийгийн улмаас гэмтээд бүрэн уншигдах боломжгүй боловч уг зохиолд төсгөлийн үг байсангүй гэдэг нь илэрхий. Тус гар бичмэлд Ba, Bb, Bc хувилбаруудтай агуулгын хувьд ижилхэн боловч орчуулгын хувьд харилцан адилгүй. Mong. B 1 бие даасан

<sup>300</sup> Улаангом дахь Увс аймгийн музейд хадгалагдаж байгаа гар бичмэлийн дагуу.


орчуулга болох төдийгүй төвд уг эх нь Ba, Bb, Bc хувилбарын төвд эхээс салангид өөр эх байсан байж таарна. Иймд Mong. B 1 гар бичмэлийг Bd хувилбар хэмээн нэрлэе.



Зураг 3. Bd хувилбар (Mong. B 1, fol. 1v–2r).

2. *Qutuγ-tu oyтарыуи үаҗар-un naiman gegegen neretü sudur*: (Mong. B 82) – цааш нь Be хэмээн тэмдэглэв.

Хөө тортог тогтсон оросын гар үйлдвэрийн зузаан бор цаас, цаасны усан тэмдэггүй, 17x7,5см, 28 хуудас. Гурван бичээчийн гараар бичсэн 19-р зууны эхэн хагасын хулсан үзгийн бичмэл. Ba хувилбарт ойрхон боловч, зөвхөн хуулбарлагчийн алдаа дүгнэж үл болох орчуулгын чухал зөрөө буй. Тус ялгаа зөрөө бас самгард хэлний нэр томьёонд тодорхой мэдэгдэнэ.



Зураг 4. Ве хувилбар (Mong. B 82, fol. 1v-2r).

### Гарчиг болон найман бодьсадвагийн нэрийн харьцуулал

Энэ өгүүлэлд А, В хувилбаруудыг дэлгэрэнгүй харьцуулах боломжгүй тул, тэдний гарчиг болон “Найман гэгээний” ихэнх судрын гол хэсэг болох найман бодьсадвагийн нэрийг харьцуулж үзье.

1.) **Mong. B 1 (Bd)** гар бичмэлийн гарчиг:

*namō buddhāy-ā:: namō dharmāy-ā:: namaḥ sangghāy-ā::*

*hendkeg-ün keleber: ary-a barang sanggas sdang:*

(мөр зэрэгцүүлсэн нэмэлт төвд үсгээр бичсэн гарчиг: *pa ra yang gyad te/da?*)

*töbed-ün keleber: gbagspa. gnam sa snang brgyad žes byab-a tigba čenbo yi mdo::*

(мөр зэрэгцүүлсэн нэмэлт төвд үсгээр бичсэн гарчиг: *grnam sa snang brgyad zhes bya ba*)

*mongyol-un keleber: qutuy-tu oytaryui yaǰarun naiman gegegen neretü yeke*



*kölgen sudur*::

2.) Олон сүмээс олдсон **OS IV/137** тасархай гар бичмэл,<sup>301</sup> дутуу хэсгийг PLB 205 буюу В а хувилбараар нөхвөрлөж дөрвөлжин хаалтад оруулав):

[*Namo buddhaya.*] / [*Namo dharmaya.*] / [*Namo sangghaya.*]

[*Hindkeg-ün keleber. ariya yuu*] **singgi. nama sudur-a.**

[*Töbed-ün keleber. 'pagspa namasa*] **asang ijad. ses**

[*byaba tigba činbui imdo. mongy*] **olun keleber.**

[*qutuy-tu qarsi jasaq*] **u naiman gegen neretü**

[*sudur ...*]

3.) **Ba:** ... *Hindkeg-ün keleber. ariya juu singgi. nama sudr-a*<sup>302</sup> *töbed-ün keleber: 'pagspa nam-a s-a isnang irjad: sin byab-a tigba činboi imdo mongyol-un keleber: qutuy-tu: oytaryui yařar-un naiman gegegen neretü sudur:*

4.) **Bb:** ... *Nanggiyad-un keleber: ary-a bar-a yang gyad irda: töbed-ün keleber: bagsba bnam sa isnang irgyad zin byav-a tigba čenboi imdo:: mongyol-un keleber naiman gegen neretü yeke kölgen sudur::*

5.) **Bc:** *Enedkegin kelen du aryā pa kara jevara na ma mahā ya na sudrā: töbö-diyin kelen du gpaqs pa gnamsa bjed gšes jeva tegpa čen bui mdo: mongyoliyin kelen du xutu-qtu oqtoryui yazariyin nai-man gegēn kemekü yeke külgüni sudur:*

6.) **Aa:** *Enedkeg-ün keleber: ariy-a-y-a (эсвэл: j-a) bang sudur-a nam-a:: töbed-ün keleber: bagsba nam ša is nang irjad tigba čenboi imdo: mongyol-un keleber qutuy-tu oytaryui yařar-un naiman gegegen neretü yeke kölgen sudur naiman jüil-iyer geyigsen geyigülügen: qutuy-tu ene tarni:*

7.) **Ab:** Бээжингийн Ганжуур дахь “зассан” самгард болон төвд гарчгууд:

*Ārya-kakanapaṃaṣṭavairocana-nāma-mahāyānasūtra*

*'Phags pa gnam sa snang brgyad ces bya ba theg pa chen po'i mdo*

Л.Лигети Bb дэд хувилбарын самгард гарчиг *ary-a bar-a yang gyad (i) rda*-г хятад *Bayang shen zhou jing* 八陽神咒經 хэмээхийн эвдэрсэн хэлбэр мөн хэмээн үзэв.<sup>303</sup> Энэтхэгийн үүсэл гарлын янз гаргахын төлөө *Fo shuo* 佛說-г самгард *Ary-a* гэдгээр орлуулсан. Дээрх харьцуулснаас үзвэл Bb, Ba хувилбараар дамжуулсан самгард (энэтхэгийн) хэмээгдсэн гарчгийг бодвол Bd хувилбарын *barang sanggas sdang* гэсэн гарчиг хятад эхтэй нь илүү ойр болно.

<sup>301</sup> Heissig, W: *Die mongolischen Handschriften-Reste...*, 1976.

<sup>302</sup> Модон бар Mong. D 223, fol. 1 дахь гараар тэмдэглэсэн төвд галиг: *gco bo'i shing kyī na mā.*

<sup>303</sup> Ligeti, L.: *Autour du Säkiz yükmäk yaruq*, т. 317–318.

### Найман бодьсадвагийн нэрийг харьцуулсан хүснэгт

А хувилбарт найман бодьсадвагийн нэр дан санскрит хэлбэрээр дурдагдсан бол В хувилбарт бодьсадва болгоны нэр гурван хэлний хэлбэрээр оруулсан байдаг. А хувилбар дахь бодьсадвагийн санскрит нэр уйгар хэлний нөлөө үзүүлдэг гэдгийг Л.Лигети тодруулсан.<sup>304</sup> Харин В хувилбар дахь “энэтхэгийн” гэсэн нэр үнэндээ санскрит хэлний хувилбар биш хятад нэрийн эвдэрсэн галиг болох нь илэрхий. Дараах жагсаалтад найман бодьсадвагийн нэрийг Vd хувилбарын дэс дарааллаар тавья:

#### Нэгдүгээр бодьсадва

Bd: kitad-un keleber: du sda / ha ha:

Bb: nanggiyad-un keleber: q-a q-a q-a q-a: (нэгдүгээр бодьсадва)

Be: enedkeg-ün keleber da da hā bodisung (нэгдүгээр бодьсадва)

Bc: enedkegiyin kelen du da ha ra:

Bd: töbed-ün keleber: / skyabsča dang rnam bar / rol bai byang čub / sems dba':

Bb: töbed-ün keleber: isjabčan dang irnambar grolbai byanbčub semba:

Be: töbed-ün keleber: eskib cilbo dang rnam bar 'grol bai sang čüb semba dang?

Bd: mongyol-un keleber: / yeke itegel-tü tegsi / aldarsiysan bōdhi sato [=satwa]: /

Bb: mongyol-un keleber: yekede ibegegči kiged teyin böged tonilyayči bodistwa:

Be: mongyol-un keleber: yeke itegel kiged: oγuyata tonilyayči neretü bodisung:

Bc: mongyoliyin kelen du: yeke ubēl maši getülüqsen bo-dhi sadv kemeküi:

Tib.: skyabs chen dang byang chub sems dpa'

Chin.: 跋陀羅菩薩 Batuoluo Pusa (var. 颯陀和菩薩 N.427)

Skr.: Bhadra

Uygh.: Badra / Btra

Mong. A: Badir-a

#### Хоёрдугаар бодьсадва

Bd: kitad-un keleber: / [18v] lo lan ki ha::

Bb: nanggiyad-un keleber: malen isjibu q-a: (хоёрдугаар бодьсадва)

Be: enedkeg-ün keleber: rawan bodisung. (дөрөвдүгээр бодьсадва))

Bc: enedkegiyin kelen du: la men ku hā:

Bd: töbedün / -ün[!] keleber bla na bai / rnam bar rol bai: byang / cub sems dba':

Bb: töbed-ün keleber: blan-a midba dang irnambar grolbai byangčub semba:

<sup>304</sup> Ligeti, L.: *Autour du Säkiz yükmäk yaruq*, т. 317.

Be: töbed-ün keleber: blan-a medba dang: rnam bar 'grol bai sang čüb semba dang.

Bd: mongyolun / keleber: tengsel-ügei tegsi / aldarsiysan bōdhi sato [=satwa]:: /

Bb: mongyol-un keleber: tengsel ügei kiged teyin böged tonilyayči bodistwa:

Be: tengsel-ügei kiged oγuyatan tonilyayči neretü bodisung:

Bc: mongyo-liyin kelen du: dedü ügei kigēd maši toniluqsan bodhi sadv::

Chin.: 羅鄰竭菩薩 (var. 羅憐那竭菩薩 N. 427) Luolin[na]jie Pusa

Uygh.: Ratnakar ?

Mong. A: Radnaggiri ? / Rading gir-a ?

Гуравдугаар бодьсадва

Bd: kitad-un keleber: kiu bo / de bdo ha::

Bb: nanggiyad-un keleber: kyu bo kiu qu: (гуравдугаар бодьсадва)

Be: enedkeg-ün keleber: keu da ha bodisung: (гуравдугаар бодьсадва)

Bc: enedkegiyin kelen du: jeve bhe niu hā:

Bd: töbed-ün / keleber: dgi bawi gsis gmin / dang: don rnam bar: / rol bai: byang čub sems / dba-a:

Be: töbed keleber: gib-a yi sinin dang rnam bar: 'grol bai: sang čüb semba dang:

Bb: töbed-ün keleber: gbai šisain dang irnambar grulbai byangčub semba:

Bd: mongyol-un keleber: / buyan-i erkin tusabar tegsi / aldarsiysan bōdhi sato [=satwa]:: / [19r]

Bb: mongyol-un keleber: buyan-tu baysi kiged teyin böged tonilyayči bodistwa: [236r]

Be: mongyolun keleber: buyan-u ündüsün-i darulayči kiged: oγuyata tonilyayči neretü bodisung:

Bc: mongyoliyin kelen du: buyani nökör sadun ni-dün maši getülüqsen bodhi sadv::

Tib.: dge ba'i bshes gnyen dang byang chub sems dpa'

Chin.: 橋自兜菩薩 Qiaozidou Pusa 自 zi > 白 bai/bo, var. 橋曰兜菩薩 Qiaoyuedou (N. 427)

Uygh.: Kumut / Kümüt

Mong. A: Kümüd

Дөрөвдүгээр бодьсадва

Bd: kitad-un keleber: so bi / sau hā::

Bb: nanggiyad-un keleber: bašaq-a: (наймдугаар бодьсадва)

OS:<sup>305</sup> enedkeg-ün keheber: avulokita busud tan bodistva (тавдугаар бодьсадва)

Ba: enedkeg-ün keheber avalokita bisudtani bodisung (тавдугаар бодьсадва)

Be: enedkeg-ün keheber: sonbi siri maq-a: (тавдугаар бодьсадва)

Bc: enedkegiyin kelen du: bobhi širi hā:

Bd: töbed-ün / keheber sbyan rnam bar dag / ba dang rnam bar rol bawi / byang čub sems dba'::

Bb: töbed-ün keheber: isčan irnam bar dagba dang irnambar grulbai byangčub sembe:

OS: töbed-ün keheber: ibsan irnam bar tayba dang///bai görölbei sang čöb semba dang

Ba: töbed-ün keheber: ibsan irnambar. tay ba dang irnambar görölbei sang čöb sembadang

Be: töbed-ün keheber: sbyan rnam bar digba dang: nam bar sgrol bai bsang čüb sem ba dang:

Bd: mongyol-un keheber: ünen / ariyun nidütü: tegsi / aldarsiysan bōdhi sato [=satwa]: /

Bb: mongyol-un keheber: ariluysan nidütü kiged teyin böged tonilyayči bodstwa:

OS: mongyolun keheber: nidun-i oluysan kiged. oγuyata tonilyayči neretü bodisung

Ba: mongyolun kele-ber. ariyun nidün-i oluysan kiged. oγuyata tonilyayči neretü bodisung

Be: mongyolun keheber: ariyun nidün-i oluysan kiged: oγuyata tonilyayči neretü bodisung:

Bc: mongyoliyin kelen du: nidün maši getülüqsen bodhi sadv'::

Tib.: Spyān rnam par dag pa dang rnam par grol ba'i byang chub sems dpa'

Chin.: 無緣觀菩薩 Wuyuanguan Pusa

Skr.: Avalokita-viśuddhana

Uygh.: Atqančsüz diyan

Mong. A: Atqay-sun diyan / Adqani diyan

#### Тавдугаар бодьсадва

Bd: kitad-un keheber: ile bra / ha:

Bb: nanggiyad-un keheber: nala yanaq-a: (тавдугаар бодьсадва)

Be: enedkeg-ün keheber: maq-a jaba bodisung: (хоёрдугаар бодьсадва)

Bc: enedke-giyin kelen du: na la hā ri:

<sup>305</sup> Олон сүмийн гар бичмэлийн тасархай.



Bd: töbed-ün keleber: / rab dbal dang ... bar / byang bawi byang čub / sems dba'::

Bb: töbed-ün keleber: riboi baldang irnambar krulbai byangčub semba:

Be: töbed-ün keleber: rab pal dang: rnam bar: 'grol bai sang čub semba dang:

Bd: mongyol-un / keleber: čoy-tu ayula-yin / [19v] tegsi aldarsiysan bōdhi / sato [=satwa]::

Bb: mongyol-un keleber: čoytu ayula kiged teyin böged tonilyaçi bodstw:

Be: mongyol-un keleber: čoytu ayula kiged: oyuyata tonilyaçi neretü bodisung:

Bc: mongyo-liyin kelen du: coq oula kigēd ma-ši toniluqsan bodhi sadv'::

Tib.: ri bo'i dpal dang rnam par grol ba'i byang chub sems dba'

Uygh.: Sümür täring

Chin.: 須彌生菩薩 Xumisheng Pusa (var. 須深彌菩薩 Xushenmi N. 427)

Skr.: \*Śrī-sumeru

(Bb, Bc хувилбарын дагуу:) Skr.: Nārāyaṇa

Chin.: 那羅達菩薩 Naluoda Pusa

Uygh.: Narayan

Mong. A: Narayan

### Зургадугаар бодьсадва

Bd: kitad-un keleber: / idi ra ha:

Bb: nanggiyad-un keleber: idhadhi raqan-a: (долдугаар бодьсадва)<sup>306</sup>

OS: enedkeg-ün keleber. ini tarasa bodisung (долдугаар бодьсадва)

Ba: [enedkeg-ün keleber] - (долдугаар бодьсадва)

Be: enedkeg-ün keleber: andiri ha bodisung:

Bc: enedke-giyin kelen du: indi ra hā:

Bd: töbed-ün keleber: / wagor lo bskyur was / rgyal bo dang: rnam bar / dang bawi: byang čub sems / dba':

Bb: töbed-ün keleber: khorlo isčur ʒai irʒalbo dang irambar krulbai byangčub semba:

OS: töbed-ün keleber. görlön ʒurbai irgal bodang irnambar görölbai sang čöb sembadang

Ba: töbed-ün keleber. görlö nis gürbai irgal bodis budang irnambar görölbai sang čöb semba dang

Be: töbed keleber: borlo [!] isčur b-a yi rgyalbo dang: nam bar sgröl bai sang čüb semba dang:

Bd: mongyol-un keleber: / tegsi aldarsiysan kürdün-ü / qayan bōdhi sato [=satwa]::

<sup>306</sup> Ligeti, L.: *Autour du Säkiz yükmäk yaruq*, т. 307. *E dha dha ra ha na*.

Bb: mongyol-un keleber: kürdün orčiyluyçı qayan kiged teyin böged tonilyayçı bodstwa:

OS: mongyolun ... tonilyayçı neretü bod istva

Ba: mongyol-un keleber. kürdün orčiyluyçı qayan kiged: oyuyata tonilyayçı neretü bodisung.

Be: mongyol-un keleber: kürdün orčiyluyçı qayan kiged: oyuyata tonilyayçı neretü bodisung:

Bc: mong-yoliyin kelen du: kürdü orčiulu-qçı xān kigēd maši getülüşen bodhi sadv.:

Tib.: 'khor los sgyur ba'i rgyal po dang rnam par grol ba'i byang chub sems dpa'

Chin: 因桓達菩薩 Yinhuanda Pusa, var. 因祇達菩薩 Yinzhida Pusa (N. 427)

Uygh.: Intiri

Mong. A: Indaradati, Indiradati

Долдугаар бодьсадва

Bd: kitad-un / keleber: ha lin gitu hi: /

Bb: nanggiyad-un keleber: qilin kyuq-a: (зургадугаар бодьсадва)

OS: enedkeg-ün keleber. vimali bisdada bodistv-a (зургадугаар бодьсадва)

Ba: enedkeg-ün keleber. bimali bisoda bodisung (зургадугаар бодьсадва)

Be: enedkeg-ün keleber: nalin gib-a ha bodisung: (зургадугаар бодьсадва)

Bc: enedkegiyin kelen du: li la geu hā:

Bd: töbed-ün keleber: sgrib / ba rnam bar dag ba dang: / rnam bar rol bawi byang / čub sems dba': /

Bb: töbed-ün keleber: drim-a irnambar dagba dang irnambar krulbai byangčub semba:

OS: töbed-ün keleber. tirman irnam bar taybar görölbai sang čöb semba dang

Ba: töbed-ün keleber: tirma rnam bar taybdang irnambar göröl bai. sang čöb semba dang.

Be: töbed-ün keleber: darim-a nambar digba dang: nam bar sgrol bai sang čüb semba dang:

Bd: mongyol-un keleber: ariyun-a / nigül tüidker-i tegsi / arilyayçı bōdhi sato [=satwa]: /

Bb: mongyol-un keleber: gkir-i arilyayçı kiged teyin böged tonilyayçı bodistwa:

OS: mongyolun keleber kir uququi arilyayçı kiged oyuyata tonilyayçı neretü bodistva

Ba: mongyol-un keleber gkir nuyud-i arilyayçı kiged oyuyata tonilyayçı bodisung

Be: mongyol-un keleber: gkir nuyud-i arilyayči kiged: oγuyata tonilyayči neretü bodisung:

Bc: mongyoliyin kelen du: kir maši arilun: maši ge-tülüksen bodhi sadv::

Tib.: dri ma rnam par dag pa grol ba'i byang chub sems dpa'

Skr.: Vimalanetraḥ (according to *Mahāvīyutpatti* No. 677 *gkir-ügei nidün / gkir-ügei nidü-tü*)

Chin.: 和輪調菩薩 (Хятад болон санскрит нэр зургадугаар бодьсадвад холбогдоно)

Skr.: *Cakravartin*

Uygh.: Turuq-süzük

Mong. A: Turuy-süsüg

### Наймдугаар бодьсадва

Bd: kitad-un keleber: mi dung ma hā::<sup>307</sup>

Bb: nanggiyad-un keleber: mirduy maq-a: (наймдугаар бодьсадва)

OS: enedkeg-ün keleber. mir tay maqa bodistva (наймдугаар бодьсадва)

Ba: enedkeg-ün keleber. martay maqa bodisung. (наймдугаар бодьсадва)

Be: enedkeg-ün keleber: mirdung mi ha bodisung: (наймдугаар бодьсадва)

Bc: enedkegi-yin kelen du: moq deq me hā:

Bd: töbed-ün / keleber: wa thon sgyur dang / rnam bar rgyal was byang / čub sems dba'::

Bb: töbed-ün keleber: ton isčur dang irnambar grulbai byangčub semba:

OS: töbed-ün keleber. ton čur tang irnam bar göröl bai sang čöb semba [dang]

Ba: töbed-ün keleber. tončurtang irnambar görölbai sang čöb sembadang.

Be: töbed-ün keleber: tončor dang: rnam bar sgröl bai sang čüb semba dang:

Bd: mongyol-un / keleber: jokis-ügei tegsi / učiral-tu sača ilayuysan / bōdhi sato [=satwa]::

Bb: mongyol-un keleber: adali yabdul-tu kiged teyin böged tonilyayči bodistwa:

OS: mongyolun [keleber jokiyangyui tayalayči kiged oγuyata tonilyayči [bodist]va

Ba: mongyol-un keleber. jokiyangyui tayalayči kiged: oγuyata tonilyayči neretü bodisung

Be: mongyol-un keleber: jokiyangyui tayalayči kiged: oγuyata tonilyayči neretü bodisung:

Bc: mongyoliyin kelen du: zokildu-xui učiral kiged maši getülük-sen bodhi sadv::

Bd дэд хувилбарт Дөрөвдүгээр бодьсадваг хоёр дахь удаа бага


<sup>307</sup> Ligeti, L.: *Autour du Säkiz yükmäk yaruq*, т. 307. *E dha dha ra ha na*

зөрөөтэй төвд, монгол нэртэйгээр есдүгээр бодьсадва мэт дурдсан байна:

Bd: kitad-un / keheber so bi sau hā:: /

Bd: töbed-ün keheber: sbyan / rnam bar rol bawi byang / [20v] čub sems dba': yadi / byad kyi bka'a bhin ba dang: /

Bd: mongyol-un keheber: tegsi / aldarsiysan <nidütü> bōdhi sato [=satwa] /



3ypar 5. Mong. B 1, fol. 18r.




3ypar 6. Mong. B 1, fol. 18v-19r.





1. титэм – өчүүхэн арын титэм
2. нуруу – зузаан, баруун талаас таслалгүй тэгш, тууш шугамт
3. шүд – гурвалжин хэлбэртэй; *ke/ge, ba/be* буюу нуманд залгасан тохиолдолд дээшээ дорсгойдон бичигдэнэ
4. шилбэ – дохигор хэлбэртэй
5. *ǰ/у* үсгийн шилбэ – үгийн эхэнд *ǰ, у* хоёр ялгараагүй, этгэр шилбийн тодорхой дэгээгүй; дохигор хэлбэртэй *i* үсгийн шилбийг бодвол дундаа хотойсон маягтай
6. эрвээлжин шилбэ – солбицсон зураас хэлбэртэй
7. эвэр – *č/ǰ* авиа ялгараагүй, орчин үеийн *č* үсэг маягийн хэлбэртэй бичигдэнэ; дэвсгэр *g* үсгийн дараах *č* үсгийн гол зураас урдах нуманд урагшин түрвийж бичигдэнэ
8. нум – *k, g* үсгийн зурлагын эхэн аараг эвэртэй хэлбэрээр бичигдэнэ (галигийн га үсэгтэй ойролцоо)
9. босоо т – хоёр зурааснаас бүрдсэн гонзгор гурвалжиндуу хэлбэртэй үсэг; эхний зураас нь дотогшоо хотойсон байдаг
10. хэвтээ д – хэтэрхий бултайн цухуйж буй дэлгүү хэлбэртэй үсэг; зураасны эцэс ихэнхдээ задгай, нурууны шугамтай нийлдэггүй
11. богино сүүл – үгийн адагт орсон *s* үсгийг ямагт богино сүүлээр тэмдэглэнэ
12. цацлага – чанх зүүн тийш гозойн бичигдэнэ; үгийн адагт орсон *g* үсэг эрвээлжин шилбэ маягийн шүдээр эхэлдэг (гэхдээ тус гарын тигийн солбицсон зураас хэлбэртэй эрвээлжин шилбээс зөрөөтэй буюу үзгийг цааснаас холдуулалгүй ацлан салаалж бичнэ)
13. л үсгийн эвэр – гох маягийн хонхгор зураасны хэлбэртэй
14. цэгийн бичлэг – *n, γ, š* үсэг ихэнхдээ цэггүй бичигддэг боловч цэгтэй бичсэн тохиолдол ч цөөнгүй буй: жишээ нь: *neretü* (fol. 1v).



Зураг 9. Vd хувилбарын гар бичмэлийн палеографийн задлал

### Хэлний онцлог

Хэлзүйн онцлогийг өгүүлвэл Bd орчуулгад үйл үгийн нөхцөлдүүлэн холбох *-rın / -rün* дагвар буюу "converbum praeparativum" идэвхтэй хэрэглэгддэг бол Ba, b, c хувилбаруудад тус нөхцөл өөр цагаар төгсгөх буюу тодотгон холбох дагавраар орчуулагдсан байдаг. Жишээ нь:

Bd: *ilaǰu tegüs nögčigsen / Sigemuni burqan sayuǰu / bürün:*

Bb: *ilaǰu tegüs nögčigsen burqan sayun bülüge:*

Bc: *ilayun tögösün üleqsen ilyuqsan Šakǰimuni souxui du:*

Be: *ilaǰu tegüs nögčigsen burqan luy-a nigen-e sayun bülüge:*

Bd: *eyin kemen öčirün:*

Bb: *teyin kemen öčigsen-tür.*

Bc: *eyin kemēn ayildxabai:*

Be: *eyin kemen öčibei:*

Бас *sača* сул үг бэлтгэн холбох нөхцөлийн утгаар урьдчилан холбох дагавартай хэрэглэгдэнэ: *tarni ögüleged sača: (17v, 24r), ene tarni-yi / ungsiyad sača: (29r)*

Мөн түүнчлэн сонгодог өмнөх үеийн сул үг *ele* B d хувилбарт элбэг хэрэглэгдэнэ:

Bd: *minü sonusuysan nigen čay-tur ele: (2r)*

Bb: *eyin kemen minü sonusuysan nigen čay-tur: (232r)*

Bd: *tegüber ele yeke kölgen / nom oytaryui yaǰarun / naiman gegegen neretü ene / nom-i ungsibasü: (31v)*

Болзон холбох дагавартай хамт хэрэглэдэг *ele* сул үг хожмын үеийн хувилбаруудад ч буй:

Bd: *yambar / ba üile-yi üiledteküi- / tür mayui odun-tur / učirabasu: gem-ten yaǰar / usun-i eǰed qarsilaqui / **bolbasu ele: em ba: / eldeb terigüten-iyer / ĵasamui:: (23r)***

Bb: *aliba sayin üiles terigüten-i üiledküi-tür: edeger odud-un gem bolqu-yin tula: yaǰar-un eǰen luus-un qad kilinglekü **bolbasu ele: eldeb em-ün kiged ünen-ü küčün-iyer ĵasamui: (236v)***

Bd: *amuyulang ĵiryalang sedkil-iyer / **ese nomuqadbasu ele: / terigün-i tan-i arčika / modun-ü köbege metü: / doluyan anggi qayalqu boluyu: (24r)***

Bb: *sansar nirwan-u yaǰar-un eǰen luus-un qad amurlingyui sedkil-iyer **ese nomuqadqabasü ele: terigün anu doluyan anggi qayaraqü boluyu: (236v)***

Зөв бичихзүйн онцлогоос нэрийн тийн ялгалыг (юуны өмнө хамаатуулах, заах) үгийн үндэстэй залган бичих зарчим элбэг харагдана. Жишээ нь: *yaġarun eġen, bodisung narun* (12r), *tegüni* (3v), *möndüri* (30r).

### Дүгнэлт

Mong. В 1 буюу “Харш засах найман гэгээн” судрын Vd хувилбар эрдэм шинжилгээний бүтээлүүдэд өмнө дурдагдаж байгаагүй нэгэн шинэ орчуулга болно. Тус орчуулга нь Олон сүмээс олдсон В хувилбарын тасархай хуудасны дэд хувилбар болон 18-р зууны эхээр модон бараар тус тус хэвлэгдэж гарсан баримжаалсан Va, Vb хувилбараас хэлний өвөрмөц шинжийн талаар дунд оршиж байгаа хувилбар буюу 17-р зууны шинжтэй хувилбар боловч Олон сүмийн эсвэл модон барын хувилбартай эх бичгийн холбоотой гэхээс илүү биеэ дааж үүссэн орчуулга болно. Одоохондоо тодорхойлж олдоогүй боловч Vd дэд хувилбарын төвд эх нь ч гэсэн Va, Vb дэд хувилбарын төвд эхээс тустаа байсан магадлал ихтэй. 18-р зууны эхээр модон барын монгол судар хэвлэгдэж түгээмэл дэлгэрсэн боловч шинэ орчуулгын шинжтэй шинэ хувилбарууд үүсэж зогсоогүй гэдгийг гэрчилдэг Ve 19-р зууны эхний хагасын хувилбарыг бас дурдав. В хувилбарын бүх дэд хувилбарт гардаг найман бодьсадвагийн санскрит (жинхэнэ утгаар хятад гаралтай) болон төвд зэрэг гадаад үсэг бичгээс галиглан оруулсан нэрийг харьцуулвал Vd хувилбар тухайн нэр томьёоны хятад эхтэй харьцангуй ойр болно гэсэн саналыг тус өгүүлэлд дэвшүүлэв.

### Ном зүй

Bang, Willi – von Gabain, Annamarie – Rachmati, Gabdul Rašid: *Türkische Turfantexte VI. Das buddhistische Sūtra Säkiz yükmäk*. Berlin 1934. (Sonderausdruck aus den Sitzungsberichte der Preussischen Akademie der Wissenschaften, Phil. Hist. Klasse. 1934. X.).

Feng Jiasheng 馮家升: Keben huihuwen “Fo shuo tian di ba yang shen zhou jing” yanjiu – Jian lun Huihuren dui “Dazangjing de gongxian 刻本回鶻文〈佛說天地八陽神咒經〉研究-兼論回鶻人對於〈大藏經〉的貢獻. *Kaogu xuebao* 考古學報 9 (1955), pp. 183–192, 277–278. [Уйгар модон барын “Хутагт тэнгэр газрын найман гэгээн судрын” судалгаа: Дазанцзинд Уйгар хүний үзүүлсэн хувь нэмэр. In: *Археологийн судалгаа*]

Heissig, Walther: *Die mongolischen Handschriften-Reste aus Olon süme Innere Mongolei (16.–17. Jahrhundert)*. (Asiatische Forschungen 46) Otto Harrassowitz, Wiesbaden 1976.



- Heissig, Walther: *Die Pekinger Lamaistischen Blockdrucke in mongolischer Sprache. Materialien zur mongolischen Literaturgeschichte.* Otto Harrassowitz, Wiesbaden 1954.
- Ligeti, Louis: Autour du Säkiz yükmäk yaruq. In: *Studia Turcica.* Ed. by L. Ligeti. Akadémiai Kiadó, Budapest 1971, pp. 291–319.
- Ligeti, Louis: *Catalogue du Kanjur mongol imprimé. Vol. I – Catalogue.* (Bibliotheca Orientalis Hungarica III) Société Kőrösi Csoma, Budapest 1942–1944.
- Liu Yuanchun 劉元春: “Fo shuo tian di ba yang shen zhou jing” bianxi: Jian tan Gaochang Huihu fojiao de shehui wenhua yiyun 《佛說天地八陽神咒經》辨析-兼談高昌回鶻佛教的社會文化意蘊. *Xiyu yanjiu* 西域研究 1996, Vol. 1, pp. 50–59. [“Хутагт тэнгэр газрын найман гэгээн судрын” задлал: Гаочан Уйгарын бурханы шашны нийгмийн соёлын коннотаци. In: Баруун газрын судалгаа]
- Mergen keyid-ün sudur-un čiyulyan.* Ed. by S. Mönkebatu. 7 volumes. Öbür mongyol-un suryan kümüjil-ün keblel-ün qoriy-a, Kökeqota 2012.
- Radloff, Wilhelm: Kuan-ši-im Puser. Eine türkische Übersetzung des XXV. Kapitels der chinesischen Ausgabe des Saddharmapuṇḍarīka. In: *Bibliotheca Buddhica XIV.* St. Petersburg 1911.
- Radloff, Wilhelm: *Uigurische Sprachdenkmäler.* Ed. by S. Malov. Leningrad 1928.
- Weber, Julius – Huth, Georg: Das buddhistische Sūtra der „Acht Erscheinungen.“ *Zeitschrift der Deutschen Morgenländischen Gesellschaft* Vol. 45 (1891), pp. 577–591.
- Yoshida, Jun'ichi – Chimeddorji: *Study on the Mongolian documents found at Qaraqota.* Yuzan kaku, Tokyo 2008.